



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙГ ОРОН НУТГИЙН
ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГАД НИЙЦҮҮЛЖ, ХЭРЭГЖИЛТИЙГ БҮРЭН ХАНГУУЛАХАД
АНХААРАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

АУДИТЫН СЭДЭВ: УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2021 ОНЫ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ОРА-2022/16-13-ШТА-ТД



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор
Ц.Нармандах

Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер Б.Эрдэнэ

Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Ахлах аудитор В.Жавзмаа

Утас: 70350757 Цахим хаяг: javzmaav@audit.gov.mn

Аудитор Б.Бямбатогтох

Утас: 70350757 Цахим хаяг: byambatogtokhb@audit.gov.mn

Эрдэнэт хот
2022 он



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2022 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/05

Эрдэнэт

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх бүрэн эрх”-ийн 2.4 дэх хэсэг, “Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам”-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улсын төсвийн 2021 хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”, “Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Аудитын гуравдугаар газар, Нийслэлийн аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргад хүргүүлсүгэй.

4. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2022 оны 11 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Д.Мөнхбат/, аймгийн Засаг дарга /С.Батжаргал/, Орон нутгийн өмчийн газрын дарга /Л.Оюунгэрэл/, ХББЗА ОНӨААТҮГ-ын захирал /Ц.Баяржаргал/, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга /Д.Цолмон/-д зөвлөсүгэй.

5. Аудитын тайлангаар өгсөн зөвлөмж, албан шаардлага, тогтоосон актын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2022 оны 4 дүгээр улиралд гарган танилцуулахыг ахлах аудитор /В.Жавзмаа/, аудитор /Б.Бямбатогтох/ нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

D:\my doc \bichig hereg\ tushaal \ 2022.doc

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 05
дугаар сарын 06-ны өдрийн А/05 дугаар
тушаалын 1 дүгээр хаворалт

Аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт

6117143690
САА0073 9042606

№	Алдаа зөрчлийн товч утга	Акт, албан шаардлагын дугаар	Хариуцагч байгууллага	Мөнгөн дүн /сая.төгрөг/
Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн				
1	Орон нутгийн барьцаа хөрөнгийн данснаас 6 ТАХ-ний санхүүжилт олгохдоо 108.2 сая төгрөгийн техник хяналтын зардлыг суутгахгүй, өмнөх оны алдааг давтан гарсан.	113/04 ОРА-2022/16-13-ШТА-ТД	Аймгийн ЗДТГ-ын СТСХэлтэс	108.2
2	Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 2 ТАХ-ний гүйцэтгэгчид банкны баталгаагаар санхүүжилт олгохдоо 113.6 сая төгрөгийн техник хяналтын зардал, зохиогчийн хяналтын зардал, зураг төсвийн зардлыг суутгалгүй олгож, төсвийн дансанд төвлөрүүлээгүй.	65/01 ОРА-2022/16-13-ШТА-ТД	Аймгийн ЗДТГ-ын СТСХэлтэс	113.2
3	Өмнөх онд хийсэн аудитаар аймгийн ИТХ аймгийн Засаг даргад зөрчил арилгуулахаар нийт 5 зөвлөмж, 6,149.7 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байх боловч 2019 онд хүргүүлсэн 2 албан шаардлагын хэрэгжилт бүрэн хэрэгжээгүй, зарим зөрчлүүд давтан гарсаар байна. ТАХ-ний санхүүжилтийг журмын дагуу олгоогүй, өмнөх оны алдааг давтан гаргасан, аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй.	110/01 ОРА-2022/16-13-ШТА-ТД	Аймгийн Засаг дарга, ЗДТГ	
	ДҮН			221.4
Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн				
4	Зөвлөх үйлчилгээний 344.2 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээг биет бус хөрөнгөд бүртгээгүй байна	114/05 ОРА-2022/16-13-ШТА-ТД	Орон нутгийн өмчийн газар	344.2
5	Аудитын явцад захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ажлын тайлан, холбогдох материалыг санхүүжилтийн баримттай тулган баталгаажуулахад 5 ТАХ-ний дуусаагүй, гэрээг цуцлах саналыг захиалагчид хүргүүлж, шийдвэрлэлт удааширсан.	112/03 ОРА-2022/16-13-ШТА-ТД	Аймгийн Засаг дарга, ЗДТГ	
	ДҮН			344.2
	Нийт дүн			565.6

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
БҮЛЭГ 1. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨХ ТОГТОЛЦООГ ҮР НӨЛӨӨТЭЙ БОЛГОХООР БАЙНА.	7
А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн тогтолцоо үр нөлөөгүйгээс төсөвлөлтийн шаардлага хангаагүй, орон нутгаас санал хүргүүлээгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсаар байна.	7
А.2 Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх тогтолцоо үр дүнтэй эсэхийг тодорхойлох боломжгүй байна.	8
А.3 Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх бодлогын хэрэгжилт хангаагдахгүй байна.	9
БҮЛЭГ 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ БҮРЭН ХАНГУУЛАХАД АНХААРЧ, ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	11
Б.1 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан хэдий ч төсөвлөлтөөс шалтгаалан ХАА хугацаа хоцорсоор байна.	11
Б.2 Захиалагчийн гэрээний хэрэгжилтийг хангуулах ажлын үр дүн өмнөх онтой харьцуулахад буурсан байна.	12
Б.3 Төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах хэрэгтэй байна.	14
Б.4. Засгийн газраас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг бодит гүйцэтгэлд олгож байгаа бөгөөд суутгах тооцоог үнэн зөв тооцоолж, хяналтыг сайжруулах шаардлагатай байна.	15
Б.5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг тооцож, үр нөлөөгүй хөрөнгө оруулалтыг багасгахаар байна.	15
ДҮГНЭЛТ:	17
ХАВСРАЛТУУД:	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн тайлбар

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АОУС	Аудитын олон улсын стандарт
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗТ	Зураг төсөв
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИШС	Инженерийн шугам сүлжээ
МУ	Монгол Улс
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СЯ	Сангийн яам
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
УИХ	Улсын Их Хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
УДДТ	Ус, дулаан дамжуулах төв
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮЭХ	Үйлдвэрчний эвлэлийн холбоо
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХББЗА ОНӨААТҮГ	“Хот байгуулалт, барилга захиалагчийн алба” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ЭБЦТС ТӨХК	“Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компани
ЭДЦС ТӨХК	“Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компани
Эрдэнэт ус ДТС ОНӨХК	“Эрдэнэт ус дулаан түгээх сүлжээ” орон нутгийн өмчит хувьцаат компани

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Хөтөлбөрүүдэд тусгагдсан байдал	7
Хүснэгт 2	Санал хүргүүлсэн байдал	7
Хүснэгт 3	Санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдаагүй баталсан төсөл, арга хэмжээ	10
Хүснэгт 4	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл	13
Хүснэгт 5	2021 онд эрх шилжсэн олгосон төсвийн санхүүжилт	15
Хүснэгт 6	ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансаар олгосон санхүүжилт	15

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Эрх шилжүүлсэн хугацаа хоцроосон байдал	11

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоол, МУЕА-ын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.
Аудитын зорилго	Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэсэн. Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: - Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх; - Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зарцуулалт үр дүнтэй байгаа эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн хүрээнд Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгасан зорилго, зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх, биелэлтийн явц, үр дүнг тооцон тайлагнах, үнэлж дүгнэх үүрэг хүлээсэн аймгийн ЗДТГ, ОНӨГ, ГХБХБГ, ХББЗА ОНӨААТҮГ-ын болон бусад байгууллагын баримт материалыг хамруулсан болно.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУБ-с хүлээн зөвшөөрсөн төрийн АОУС 300, 3000-д нийцүүлэн баталсан MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудаас тайлбар, тодруулга, судалгаа авч, шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийж, аудитын асуудлын шинжилгээ, аудитын загварын матриц, аудитын горимыг хэрэгжүүлэн нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдаж, аудитын менежер Б.Эрдэнэ чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор В.Жавзмаа, аудитор Б.Бямбатогтох нар 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн 2022 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэв.
Аудитын явцад учирсан хүндрэл, бэрхшээлүүд:	Аудитын явцад хүндрэл, бэрхшээл үүсээгүй болно.

Ерөнхий мэдээлэл

УИХ-аас МУ-ын 2021 оны Төсвийн тухай хуулийг 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр баталж, 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдөр тодотгосон байна.

МУ-ын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын ТАХ, барилга байгууламжийн жагсаалтад баталсан ТАХ-ээс Орхон аймгийн Засаг даргад эрх шилжих 18,979.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9, эрх шилжээгүй 38,684.0 сая төгрөгийн 13 ТАХ байна. Үүнээс 2021 онд шинээр эхлэх 18,770.0 сая төгрөгийн 7, он дамжиж үргэлжлэх 38,893.4 сая төгрөгийн 15 ТАХ байна.

ЗГ-ын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 15 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргад 2 ТАХ-г зохион байгуулах, хэрэгжүүлэх эрхийг шилжүүлж, БХБС-ын XII.1.89-д баталсан ТАХ-г 2 болгосон байна.

2021 онд шинээр хэрэгжих 3,200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ, 15,779.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ТАХ нь өмнөх оноос шилжин хэрэгжиж байна.

Шинээр хэрэгжих 3 ТАХ-ний ХАА-г 2021 онд зохион байгуулсан байна.

Өмнөх оноос шилжин хэрэгжсэн болон 2021 онд шинээр эхэлсэн нийт 57,663.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй 26 ТАХ-д ХББЗА ОНӨААТҮГ, ГХБХБГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байна.

2021 онд 14,777.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй 11 ТАХ хэрэгжиж дууссан, 1 ТАХ хэрэгжиж дууссан боловч улсын комисс ажиллаагүй ба 28,463.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй 7 ТАХ 2022 онд үргэлжлэн хэрэгжиж, 2021 онд бүрэн дуусах ёстой 27,421.5 сая төгрөгийн 13 ТАХ дуусаагүй байна.

БҮЛЭГ 1. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТӨЛӨВЛӨХ ТОГТОЛЦООГ ҮР НӨЛӨӨТЭЙ БОЛГОХООР БАЙНА.

А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн тогтолцоо үр нөлөөгүйгээс төсөвлөлтийн шаардлага хангаагүй, орон нутгаас санал хүргүүлээгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсаар байна.

ЗГ-аас аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 2021 онд шинээр хэрэгжих 2 ТАХ, эрх шилжээгүй 5 ТАХ нь ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, МУ-ын эдийн засаг, нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, МУ-ын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт дараах байдалтай тусгагджээ.

Хүснэгт 1. Хөтөлбөрүүдэд тусгагдсан байдал

№	Нэр	Үүнээс		Тусгагдаагүй тоо
		Шууд туссан ТАХ-ний тоо	Ерөнхий байдлаар туссан ТАХ-ний тоо	
1	ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр		5	2
2	МУ-ын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл		7	
3	МУ-ын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр		2	5

Жагсаалтад батлагдсан ТАХ нь ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 71.4%, МУ-ын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 100.0%, МУ-ын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт 28.5%-тай тусгагджээ.

МУ-ын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдлийг улсын хэмжээнд тооцсон байх тул эрх шилжсэн ажлын хувьд төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн хязгаартай нийцэж байгаа эсэхийг дүгнэх боломжгүй байна.

2021 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх жагсаалтад батлагдсан ТАХ-ний 66.6% нь хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн байна.

Аймгийн Засаг даргаас 2020 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 026/1813 дугаар албан бичгээр ЗГХЭГ-ын дарга, БХБС, ХЗДХС зэрэг 10 ТЕЗ-д 2021 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ний жагсаалтад тусгуулах нийт 88,951.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 69, шилжих 18 ТАХ-ний саналыг хүргүүлжээ.

Хүснэгт 2. Санал хүргүүлсэн ТАХ

Хөрөнгө оруулалтын төрөл	2019 он		2020 он		2021 он	
	Холбогдох ТЕЗ-д хүргүүлсэн ТАХ-ний тоо	УТХО-д баталсан ТАХ-ний тоо	Холбогдох ТЕЗ-д хүргүүлсэн ТАХ-ний тоо	УТХО-д баталсан ТАХ-ний тоо	Холбогдох ТЕЗ-д хүргүүлсэн ТАХ-ний тоо	УТХО-д баталсан ТАХ-ний тоо
Шилжих	10	9	16	11	18	15
барилга	58	17	21	8	24	2
шинээр хэрэгжих	27	2	31	2	31	
тоног төхөөрөмж	14	1	26	3	14	5
Нийт	109	29	94	24	87	22

Санал хүргүүлсэн дээрх 87 ТАХ-ээс өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 15 ТАХ-г МУ-ын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар баталсан улсын

төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын ТАХ, барилга байгууламжийн жагсаалтад баталжээ.

Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт батлагдсан шинээр эхлэх 18,770.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ТАХ-д аймгийн Засаг дарга санал хүргүүлээгүй байна. Үүнд:

- Дижитал Эрдэнэт төсөл /Орхон/,
- Төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй болгох “Олон талт түншлэл” цахим хөтөлбөр /Орхон/
- Ажлын байр нэмэгдүүлэх “Олон талт түншлэл” цахим хөтөлбөр /Орхон/,
- Олон талт түншлэлийг хөгжүүлэх “Жишиг баг” төсөл /Орхон, Баян-Өндөр сум, Цагаанчулуут, Булаг, Яргуйт баг/,
- Олон талт түншлэлийн хүрээнд “Жишиг эко баг” төсөл /Орхон, Баян-Өндөр сум, Даваат, Рашаант, Наран баг/,
- Инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц /Орхон, Баян-Өндөр сум/,
- Өрхийн эмнэлгийг дэмжих тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл /Орхон/

Аймгийн Засаг даргаас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр хүргүүлсэн саналаас шилжих ТАХ-г дэмжиж, шинээр эхлэх ТАХ-д орон нутгийн хэрэгцээ шаардлага, саналыг харгалзахгүйгээр баталжээ.

Сангийн яам ТЕЗ-аас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г цахим системээр авч нэгтгэж, эрэмбэлдэг боловч тухайн орон нутгийн хэрэгцээ шаардлага, санал хүсэлттэй уялдуулсан эсэх нь тодорхойгүй, Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасан шаардлагыг хангаагүй ТАХ-г батлуулсаар байна.

Зураг төсөвгүй баталснаас зогссон дуусаагүй барилга байгууламжийн чанар байдлыг алдагдуулахгүйгээр барьж дуусгах төсвийг шийдвэрлэхэд анхаарахаар болжээ. Тухайлбал:

- Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Рашаант баг/ - Нийт төсөвт өртөг 3,957.1 сая төгрөг бөгөөд 2,500.0 сая төгрөгийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад баталж, 2022 онд төсөв батлаагүй байна.
- Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Говил баг/ - Нийт төсөвт өртөг 3,943.6 сая төгрөг бөгөөд 1,960.0 сая төгрөгийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад баталж, 2022 онд төсөв батлаагүй байна.

А.2 Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх тогтолцоо үр дүнтэй эсэхийг тодорхойлох боломжгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр хэрэгжих 7 ТАХ-ээс зураг төсөв шаардлагатай 1 ТАХ байна. Тус ТАХ-ний зураг, төсөл боловсруулах даалгаврыг Эрдэнэт хотын захирагчийн албаны дарга 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдөр боловсруулж, холбогдох техникийн нөхцөл, дүгнэлт, газрын зөвшөөрөл олгогдсон байна.

Эрдэнэт хотын захирагчийн албаны дарга 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдөр 03/18 дугаартай зураг төсөл боловсруулах гэрээг “Асгат-Өргөө” ХХК-тай байгуулсан байна.

“Асгат өргөө” ХХК нь ЗТ-1.1.2, ЗТ-2.1, ЗТ-2.3, ЗТ-3.4, ЗТ-3.5, ЗТ-6.1, ЗТ-6.2, ЗТ-6.3, ЗТ-6.4 төрлийн барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй, 2024 оны 11 дүгээр сарын 25 хүртэл тусгай зөвшөөрлөө сунгасан, хуулийн этгээд байна.

Тус компанийн мэргэжлийн архитектор, инженер, тэргүүлэх төсөвчин зураг төслийг боловсруулжээ.

Зураг төсвийг Барилгын хөгжлийн төвийн экспертүүд хянаж, 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 1452/2021 магадлалын дүгнэлтийн нэгтгэлийг баталгаажуулсан байна.

Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх тогтолцоо үр дүнтэй, үр нөлөөтэй эсэхийг мэргэжлийн экспертүүд ажиллаж дүгнэх нь зүйтэй бөгөөд магадлалын дүгнэлт гаргаж буй экспертүүдэд хяналт хэрэгжүүлдэг эсэх нь тодорхойгүй байдаг.

А.3 Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх бодлогын хэрэгжилт хангагдахгүй байна.

МУ-ын 2021 оны төсвийн тухай хууль батлахдаа Орхон аймагт шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний төсөвлөлтийн шаардлага бүрэн хангаагүй байхад баталсан байна.

Шинээр эхлэх “Инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц /Орхон, Баян-Өндөр сум/” ТАХ-г улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө баталсны дараа газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл, инженер геологийн дүгнэлт, зураг төслийг баталгаажуулсан байна. Тухайлбал:

Зураг, төсөл боловсруулах даалгавар - Эрдэнэт хотын захирагчийн албаны даргын 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 03/2021 дугаар,
Газрын захирамж – Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/128 дугаар захирамж,
 Техникийн нөхцөл:
Гадна цахилгаан хангамж – ЭБЦТС ТӨХК-ийн 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн ЭУ-21/004-А, 2 жилийн хугацаатай,
Ус хангамж, ариутгах татуурга – Эрдэнэт ус ДТС ОНӨХК-ийн 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 21/А/006, 2 жилийн хугацаатай,
Гадна дулаан хангамж – ЭДЦС ТӨХК-ийн 2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн ОР-03/2021, 2 жилийн хугацаатай.
Барилга байгууламжийн зураг төслийн магадлалын дүгнэлт – Барилгын хөгжлийн төвийн 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 1452/2021 дүгнэлт, нийт төсөвт өртөг 4,330.2 сая төгрөг

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т “хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасантай нийцэхгүй байна.

Баталгаажсан зураг, төсөвгүй барилга, байгууламжийн төсөвт өртгийг Төсвийн тухай хуульд ерөнхий тойм дүнгээр баталснаар зураг, төсвийг боловсруулж, магадлалаар баталгаажуулахад төсөвт өртөг нэмэгдэх шалтгаан болж байна. Тухайлбал зарим барилга, байгууламжийн төсөвт өртгийг 1,719.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталжээ. Үүнд:

- Сургуулийн барилга, 928 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Эрдэнэт цогцолбор сургууль/ - 1,335.0 сая төгрөг,
- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Орхон, Баян-Өндөр сум, Яргуйт баг/ - 384.6 сая төгрөг

Төсвийн тухай хуулийн 29.3.5-д шинээр эхлэх ТАХ-ний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь ТАХ-г хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар заасан.

Аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 1,800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ-ний тайлант онд санхүүжих дүнг 700.0 сая төгрөг буюу 22.2%-аар, эрх шилжээгүй 14,470.0 сая төгрөгийн 3 ТАХ-ний тайлант онд санхүүжих дүнг 485.0 – 4,000.0 сая төгрөгөөр буюу 50.0-80.0 хувиар

дутуу төсөвлөлтийн зарчмыг хангахгүй, санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдаагүйгээр баталсан байна.

Хүснэгт 3 Санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдаагүй баталсан төсөл, арга хэмжээ /сая төгрөг/

д/д	ТАХ-ний нэр	хэрэгжих хугацаа		Баталсан		Төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан байх хэмжээ	Зөрүү /тайлант онд санхүүжих-тэнцүү хуваарилсан байх/
		Эхлэх	Дуусах	төсөвт өртөг	тайлант онд санхүүжих дүн		
1	"Дижитал-Эрдэнэт" төсөл /Орхон/	2021	2023	10,000.0	1,000.0	5,000.0	(4000.00)
2	Төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй болгох "Олон талт түншлэл" цахим хөтөлбөр /Орхон/	2021	2022	1,800.0	700.0	900.0	(200.00)
3	Олон талт түншлэлийг хөгжүүлэх "Жишиг баг" төсөл /Орхон, Баян-Өндөр сум, Цагаанчулуут, Булаг, Яргуйт баг/	2021	2022	1,970.0	500.0	985.0	(485.00)
4	Олон талт түншлэлийн хүрээнд "Жишиг эко баг" төсөл /Орхон, Баян-Өндөр сум, Даваат, Рашаант, Наран баг/	2021	2022	2,500.0	600.0	1,250.0	(650.00)
ДҮН				16,270.0	2,800.0	8,135.0	(5,335.0)

Орхон аймагт 2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр эхлэх 7 ТАХ-ээс 5 нь тоног төхөөрөмж худалдан авах, 2 нь барилга байгууламж барих ТАХ бөгөөд Төсвийн тухай хуулийн 4.1.24-т "хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг" гэсэн заалттай нийцэж байна.

Аймгийн Засаг даргад эрх шилжин ирсэн 2 ТАХ нь хөрөнгө оруулалтын шинж чанартай ажил байна.

БҮЛЭГ 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ БҮРЭН ХАНГУУЛАХАД АНХААРЧ, ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Б.1 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан хэдий ч төсөвлөлтөөс шалтгаалан ХАА хугацаа хоцорсоор байна.

МУ-ын 2021 оны төсвийн тухай хуулийн улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан 2 төсөл, арга хэмжээний худалдан авах, гэрээ байгуулах, санхүүжүүлэх эрхийг ЗГ-ын 2021 оны 15 дугаар тогтоолоор холбогдох салбарын сайдын багцаас аймгийн Засаг даргад шилжүүлсэн байна.

Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.13-т “захиалагч хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дах хэсэгт заасны дагуу эрх шилжүүлэх тохиолдолд төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор, хэрэв тодотгол орсон тохиолдолд батлагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор тус тус холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байх” гэж заасны дагуу шилжүүлэхээр байтал 8-29 хоногоор хугацаа хоцроосон нь худалдан авах ажиллагаа оройтож зохион байгуулах, тендер амжилтгүй болсноор цаг хугацаа алдаж ажлын чанар байдалд нөлөөлөх эрсдэл үүсгэж байна.

Дүрслэл 1 Эрх шилжүүлсэн хугацаа хоцроосон байдал



Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй болгох “Олон талт түншлэл” цахим хөтөлбөрийн төслийн техникийн тодорхойлолтыг 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймгийн Засаг даргад шилжүүлэхээр заасан байтал 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 01/376 албан бичгээр хүргүүлж, захиалагч аймгийн ЗДТГ 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдөр техникийн даалгаврыг ОНӨГ-т хүргүүлжээ.

Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтад баталж аймгийн Засаг даргад эрх шилжсэн, шинээр хэрэгжих 3,200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2,100.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 2 ТАХ-г 3 ТАХ болгож, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар цахимаар зохион байгуулсан байна. Эдгээрээс 2 ТАХ он дамжин хэрэгжих бөгөөд 1 ТАХ тайлант онд бүрэн хэрэгжиж дуусаагүй байна.

Аймгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ТЕЗ-даас эрх шилжүүлэх хугацаа, зураг төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар зэргийг ирүүлэх хугацааг тооцож, төлөвлөсөөр иржээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад зураг, төсөвгүй ТАХ-г баталсаар байгаа нь худалдан авах ажиллагааг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах боломжгүй болж, тендер шалгаруулалт 2-3 удаа зохион байгуулах, 36-189 хоногоор хоцорсон байна. Тухайлбал:

- Инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц /Гадна шугамын ажил БАГЦ-1/, /Орхон, Баян-Өндөр сум/ - 189 хоног

- Инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц /Ус дулаан дамжуулах төв БАГЦ-2/, /Орхон, Баян-Өндөр сум/ - 36 хоног,
- Төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй болгох "Олон талт түншлэл" цахим хөтөлбөр /Орхон/ - 182 хоног

Орхон аймгийн Засаг даргад эрх шилжсэн 2 ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад 2 үнэлгээний хороо байгуулжээ.

Үнэлгээний хороонд ажилласан гишүүд худалдан авах ажиллагаагаар мэргэшсэн, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, аймгийн ИТХ-аас томилсон иргэдийн төлөөллийг оролцуулж, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангасан байна.

Үнэлгээний хороод нь тендерийн баримт бичгийг Сангийн сайдын баталсан жишиг баримт бичгийн тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа, агуулга, гэрээний ерөнхий нөхцөл хэсгүүдийг өөрчилдөггүй, өөрийн эрх хэмжээний хүрээнд тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт, тендерийн баталгаа, гэрээний тусгай нөхцөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, үе шатны ажлын хуваарь, урилга зэрэг хэсгүүдэд өөрчлөлт оруулдаг байна.

Тендерийн баталгаа, гэрээний тусгай нөхцөл, техникийн тодорхойлолт, үе шатны ажлын хуваарь, урилга зэргийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд боловсруулсан байна.

Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороод урилгыг Монголын мэдээ сонинд нийтлүүлэн, tender.gov.mn болон erdenet.mn цахим хуудсанд байршуулж ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангасан байна.

Төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй болгох олон талт түншлэл цахим хөтөлбөрийн гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтад оролцсон Бодь электроникс ХХК-аас ТБОНӨХБАУХАТХ-ийн 55 дугаар зүйлийн 55.1-д заасны дагуу гомдол гаргаж, Сангийн яам хянаж, баталгаа ирүүлээгүй гомдлоо буцаасан тул тендер шалгаруулалтыг зохих журмын дагуу үргэлжлүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Сангийн яам ТЕЗ-ийн 2021 оны худалдан авах ажиллагааг үнэлээгүй байна.

Аймгийн ОНӨГ нь Орхон аймгийн 2021 оны худалдан авах ажиллагааны тайланг улирал бүр тайлагнаж, erdenet.mn, shilendans.gov.mn болон tender.gov.mn цахим хуудсанд тогтмол мэдээлж хэвшсэн байна.

ТЕЗ-ийн 2021 онд хэрэгжүүлсэн бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааны тайлан мэдээг аймгийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 01/1381, 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 01/56 дугаар албан бичгээр холбогдох маягтын дагуу гаргаж Сангийн сайдад хугацаанд нь хүргүүлжээ.

Б.2 Захиалагчийн гэрээний хэрэгжилтийг хангуулах ажлын үр дүн өмнөх онтой харьцуулахад буурсан байна.

УИХ-аас зураг төсөвгүй хөрөнгө оруулалтын ТАХ баталснаас шалтгаалан зураг төсөв боловсруулах, магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулахад хугацаа алдсанаар худалдан авах ажиллагаа хойшилж, улирлын шинж чанартай бүтээн байгуулалтын ажил он дамжин, ковид цар тахалтай холбоотой хил хаагдсанаар бүтээн байгуулалтын ажлууд бүрэн дуусаагүй байна.

Орхон аймагт 2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 23, өмнөх оноос шилжсэн дуусаагүй 9, нийт 32 ТАХ-ээс 2022-2023 онд шилжин хэрэгжих 7, бүрэн дууссан 11, дууссан боловч улсын комисс ажиллаагүй 1, хэрэгжиж дуусаагүй 13 ТАХ байх ба хэрэгжилт 36.4 хувь болж өмнөх оноос 32.3 хувиар буурчээ.

Хүснэгт 4 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл

Гүйцэтгэлийн хувь	2019 оноос шилжсэн, дуусаагүй		2021 он		Нийт ТАХ
	эрх шилжсэн ТАХ	эрх шилжээгүй ТАХ	эрх шилжсэн ТАХ	эрх шилжээгүй ТАХ	
улсын комисс ажилласан	4		1	6	11

Бүрэн дууссан	улсын комисс ажиллаагүй	1			1
	1-20% гүйцэтгэлтэй	1			1
Бүрэн дуусаагүй	21-50% гүйцэтгэлтэй				-
	51-75% гүйцэтгэлтэй		1	2	1
	76-99% гүйцэтгэлтэй	1		3	1
2021 онд гэрээ байгуулж, ажил эхлээгүй				1	1
2021 онд царцаасан ТАХ	1				1
2022-2023 онд дамжин хэрэгжих ТАХ				2	5
Баталсан төсвийн дүнгээр гүйцэтгэсэн				1	1
Нийт дүн	8	1	10	14	33
Гүйцэтгэлийн хувь					36.4

2021 онд царцаасан 2, бүрэн дуусаагүй 12, нийт 14 ТАХ-ээс бараа материалын хомсдолоос шалтгаалсан 2022 онд ашиглалтад орох 9, магадлалаар баталгаажуулж зураг төсвөөр гэрээ байгуулж, төсөвт өртөг нэмэгдүүлэхээр хүлээж буй 3, гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас шалтгаалж, гэрээ цуцлахаар болсон 2 ТАХ байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 оноос шилжсэн, 2021 онд хэрэгжсэн эрх шилжсэн 18 төсөл, арга хэмжээнд ХББЗА ОНӨААТҮГ, эрх шилжээгүй 8 ТАХ-д аймгийн ГХБХБГ захиалагчийн тавих үе шатны явцын болон техникийн хяналтыг хэрэгжүүлжээ. ГХБХБГ нь эрх шилжээгүй 8 ТАХ-д хэрэгжүүлсэн ажлын тайлан, явцын мэдээллийг зураг, тайлбартайгаар Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн байна.

Аудитаар 2021 онд хэрэгжүүлсэн 68,611.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй 33 ТАХ-г гүйцэтгэх явцад захиалагч, зураг төсөв зохиогч, холбогдох мэргэжлийн байгууллагаас хэрэгжүүлсэн хяналт, түүний гүйцэтгэл, зөрчил дутагдлын биелэлтийг хэрхэн хангуулсан эсэхийг талбайн журнал, холбогдох бусад баримт материалын хүрээнд тулган баталгаажуулав.

Барилга байгууламжийн талбайн журналд тэмдэглэснээр ТАХ-ний хэрэгжилтийн явцад хяналтын инженерүүд, зураг төсөв зохиогчид хөдөлмөр хамгааллыг дүрмийг сахиж ажиллах, үе шатны ажлыг технологийн дагуу хугацаанд нь гүйцэтгэх, дутуу болон чанаргүй хийгдсэн ажлыг дахин хийх, үе шатны ажлыг гүйцэтгэж дуусахад актуудыг холбогдох албан тушаалтнуудаар заавал баталгаажуулж байх, бараа материалын гарал үүслийн баримт бичиг, баримтыг орчуулж, сорьц дээжийг лабораторид шинжлүүлэх гэх зэрэг үүрэг даалгавар, зөвлөмжийг өгч ажилласан байна.

Захиалагчийн хяналтыг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу хэрэгжүүлж, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг фото зураг, холбогдох баримтаар баталгаажуулжээ.

Гүйцэтгэгч байгууллагууд өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, ил далд ажлын актыг цаг тухай бүр захиалагч, зохиогч нараар баталгаажуулж, фото зургаар баталгаажуулж хэвшсэн байна.

Мөн графикт ажлыг хугацаанд нь гүйцэтгэх, гэрээнд заасан хугацаанд багтаан дуусах зэрэгт ахиц гарч байгаа бөгөөд удааширсан 2 ТАХ-г гэрээг цуцлах саналаа захиалагчид хүргүүлжээ. 2021 онд дуусаагүй 9 ТАХ нь бараа материалын хомсдолоос хугацаандаа хэрэгжиж дуусаагүй бөгөөд захиалагчаас шалтгаалаагүй байна.

Илэрсэн зөрчлийг гүйцэтгэгчээр тухай бүрд нь арилгуулах арга хэмжээг авч, тодорхой үр дүнд хүрч байгаа ба захиалагчийн хяналт үр дүнтэй хэрэгжжээ.

Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтаар эрх шилжсэн тоног төхөөрөмж нийлүүлэх 1, эрх шилжээгүй 2 ТАХ баталжээ.

Эрх шилжээгүй 2 ТАХ-ээр 9 ӨЭМТ, аймгийн ҮЭХ, ХХҮГ-т 42 нэр төрлийн 266 ширхэг 1,000.9 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмж нийлүүлэхээс 970.6 сая төгрөгийн техник, тоног

төхөөрөмжийг нийлүүлж, 30.3 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмжийг нийлүүлээгүй байна. Нийлүүлсэн техник, тоног төхөөрөмжүүд техникийн тодорхойлолтод заасан үзүүлэлт, хүчин чадалтай нийцсэн эсэхийг хүлээн авсан акт, анхан шатны баримтуудаар тулгалаа.

Эрх шилжсэн 702.9 сая төгрөгийн ТАХ-ний хувьд 2021 оны 11 дүгээр сарын 23-нд гэрээ байгуулж хуанлийн 60 хоногт нийлүүлэхээр болсон хэдий ч 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийг хүртэл нийлүүлээгүй байна.

Аймгийн хэмжээнд 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар өмнөх онуудаас хэрэгжиж дуусаагүй 3 барилга байгууламж, гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас шалтгаалан зогссон 1 барилга байгууламж, 1 ИШС-ний ажил байна.

Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах санал хүргүүлсэн 69 ТАХ-ээс 29 их засвар, 26 барилга байгууламж, 14 тоног төхөөрөмж худалдан авах ажил байжээ. Үүнээс 29 их засвар, 12 барилга байгууламж жишиг зураг төсөлтэй байсан бөгөөд 8 ТАХ-г орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхэд ашиглажээ.

Б.3 Төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах хэрэгтэй байна.

Захиалагчийн хяналтыг ХББЗА ОНӨААТҮГ, ГХБХБХГазар, зохиогчийн хяналтыг зураг, төсөв гүйцэтгэгч компаниуд хэрэгжүүлсэн бөгөөд Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.4, 37.1.5, "Барилгын захиалагчийн хяналтын дүрэм"-ийн 2.2, 3.1.4, 3.4, 3.6, 3.12, 3.14 дэх заалтуудыг мөрдсөн байна.

Аудитын явцад захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ажлын тайлан, холбогдох материалыг авч санхүүжилтийн баримттай тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Цэцэрлэгийн барилга 150 суудал /Орхон Баян-Өндөр сум/-ын улсын комисс ажиллаж, хүлээн авсан актаар баталгаажуулаагүй байхад цэцэрлэг үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна.
- Хүүхдийн тоглоомын парк /Орхон, Баян-Өндөр сум, Рашаант баг/ багц-10 усан оргилуурын ажил 2020 онд бүрэн дуусаж, түршилт тохируулгын ажлыг хүлээж авахгүй, улсын комиссын үүрэг даалгаврыг биелүүлээгүй 1 жил болсон байна.
- Гэрээний үүргийн биелэлт хангагдахгүй, удааширч буй соёлын төвийн барилга /Орхон, Баян-Өндөр сум, Наран баг/, Баянцагаан багийн ИШС /Орхон, Баян-Өндөр сум/ ТАХ-үүдийн асуудлыг шийдвэрлэхгүй 1 жил болжээ.

Иймд эдгээр 4 ТАХ-ний хэрэгжилтийг хангуулах асуудлыг шийдвэрлэх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Мөн ковид цар тахалтай холбоотойгоор үүссэн нөхцөл байдлаас дуусаагүй гэж тодорхойлсон 6 ТАХ-ний хэрэгжилтийг 2022 онд бүрэн хангуулах зөвлөмж хүргүүлж, аудитын мөрөөр хяналт хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн болно.

Аймгийн ЗДТГ-ын СТЦХ нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын дагуу захиалагчийн хянаж, баталгаажуулсан ажлын бодит гүйцэтгэлийг үндэслэн 10 төсөл, арга хэмжээнд 5,527.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 3,573.9 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна. Төсвийн санхүүжилтийг 61.4 сая төгрөгөөр дутуу эрх нээж шилжүүлсэн байна.

Хүснэгт 5 2021 онд эрх шилжсэн олгосон төсвийн санхүүжилт /сая төгрөг/

№	ТЕЗ	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Гэрээний дүн	2021 онд санхүүжих дүн	2021 онд эрх нээсэн дүн	2021 онд ААНБ-д олгосон дүн	Барьцааны дансанд байршуулсан дүн
1	БШУС	3	9,616.8	9,610.9	2,200.0	2,155.0	1,955.0	200.0
2	НХХС	2	2,062.6	2,059.9	1,462.6	1,459.9	805.6	654.3

3	ЗГХЭГС	3	5,900.0	5,859.9	4,100.0	4,096.0	2,429.9	1,666.1
4	БХБС	2	1,400.0	1,390.3	1,400.0	1,390.3	336.8	1,053.5
	ДҮН	10	18,979.4	18,921.0	9,162.6	9,101.2	5,527.3	3,573.9

Б.4. Засгийн газраас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг бодит гүйцэтгэлд олгож байгаа бөгөөд суутгах тооцоог үнэн зөв тооцоолж, хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

ЗГ-ын 2019 оны 430 дугаар тогтоолоор 2019 оны эцэст банкны урьдчилгаа төлбөрийн баталгаанд 10 ТАХ-ний 2,146.5 сая төгрөгийн, орон нутгийн барьцаа хөрөнгийн дансанд 8 ТАХ-ний 1,449.0 сая төгрөгийн, 2020 онд 13 ТАХ-ний 4,072.8 сая төгрөгийн, 2021 онд 10 ТАХ-ний 9,101.2 сая төгрөгийн санхүүжилтийг шилжүүлжээ.

Банкны урьдчилгаа төлбөрийн баталгаанд байршсан 10 ТАХ-ний 2,146.5 сая төгрөгийг олгохдоо захиалагчийн баталгаажуулсан гүйцэтгэлийн дагуу Сангийн яам хянаж, холбогдох банканд чөлөөлөх шийдвэрийг өгсөн бөгөөд 2022 оны 04 дүгээр сарын байдлаар үлдэгдэлгүй байна.

Аймгийн ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан санхүүжилтийг олгохдоо Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын дагуу захиалагчийн хянаж, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлийг үндэслэн, Сангийн яамаар хянуулж, санхүүжилтийг олгожээ.

Хүснэгт 6 ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансаар олгосон санхүүжилт / сая төгрөг/

ТАХ/санхүүжилт	2019.12.31- ний үлдэгдэл	2020 онд эрх шилжсэн	2020 онд олгосон	2020.12.31- ний үлдэгдэл	2021 онд эрх шилжсэн	2021 онд олгосон	2021.12.31- ний үлдэгдэл
ТАХ-ний тоо	8	13	4	17	10	12	25
Санхүүжих дүн	1449	4072.8	4070.4	1451.4	9101.2	6230.2	4322.4

Орон нутгийн барьцаа хөрөнгийн данснаас 6 ТАХ-ний санхүүжилт олгохдоо 108.2 сая төгрөгийн техник хяналтын зардлыг суутгахгүй, өмнөх оны алдааг давтан гарсан нь Төсвийн тухай хуулийн 41.2.6-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх", Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 5.2.6-д "Барилгын ажлын зардал, техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа /цаашид "ТЭЗУС" гэх/, техник, эдийн засгийн үндэслэл /цаашид "ТЭЗҮ" гэх/, зураг төслийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, зохиогчийн хяналтын зардал, нормчлолын сангийн зардал, чанарын баталгаат хугацааны барьцааг тус тусын дансанд холбогдох баримт, материал, тоног төхөөрөмж хүлээн авсан акт зэргийг үндэслэн шилжүүлэх" гэсэн заалтуудыг зөрчиж байна. Иймд албан шаардлага хүргүүлээ.

Өмнөх оны санхүүжилт шилжүүлэх, суутган авах тооцооны үнэн зөв байдалд аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Б.5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг тооцож, үр нөлөөгүй хөрөнгө оруулалтыг багасгахаар байна.

Захиалагч барилга байгууламж болон их засварын ажлын хувьд уг ажлыг дуусах хүртэл хугацаанд, тоног төхөөрөмжийн хувьд хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр эргэлтийн хөрөнгөд бүртгэдэг байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжсэн 11 ТАХ-ээс ОНӨГ-т 5, ашиглагч байгууллагуудын хөрөнгөд 6 ТАХ-г бүртгэжээ. Мөн ОНӨГ нь дуусаагүй барилгад 13 ТАХ-г бүртгэсэн ба улсын комиссын актыг үндэслэн тухайн байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэх шийдвэрийг Засаг дарга баталгаажуулдаг байна.

Зарим ТАХ-ний хувьд баримт бичгийн бүрдүүлбэрийг хангуулах, хянах, холбогдох зөвшөөрөл авах, захирамж гаргах зэргээр 2022 онд бүртгэхээр байна.

Нийлүүлсэн техник, тоног төхөөрөмж, ашиглалтад хүлээн авсан барилга байгууламжийн ашиглалтын байдалтай танилцахад бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд өмнөх онуудад зураг, төсөвгүй тойм дүнгээр баталсан 3 ТАХ-ний төсөвт өртгийг 1,769.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан ба төсөвт өртөг үндэслэлтэй эсэхийг Барилгын хөгжлийн төв магадлал хийж, баталгаажуулжээ. Цаашид төсөвт өртгийг нэмэгдүүлэн баталж буй ТАХ-үүд үндэслэлтэй эсэхийг нэгдсэн байдлаар шинжээчийн дүгнэлт гаргуулж, дүгнэх шаардлагатай байна.

Өмнөх онд хийсэн аудитаар аймгийн ИТХ, аймгийн Засаг даргад зөрчил арилгуулахаар нийт 5 зөвлөмж, 6,149.7 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байх боловч 2019 онд хүргүүлсэн 2 албан шаардлагын хэрэгжилт бүрэн хэрэгжээгүй, зарим зөрчлүүд давтан гарсаар байна. Үүнд:

- ТАХ-ний санхүүжилтийг олгохдоо үе шатны гүйцэтгэлээс захиалагчийн хяналтын зардал, зураг төсвийн үнэ болон зохиогчийн хяналтын зардлыг суутгалгүй гүйцэтгэгчид олгосон.
- Алдаа давтагдаж байгаад аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дотоод хяналт хэрэгжээгүй, хариуцлагагүй ажилласан байна.
- Улсын комисс ажиллаж өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг шаардаж, ТАХ-г дуусгахыг шаардаагүй байна.

Өмнөх онуудад гаргасан алдаа зөрчил давтан гарч, түүнийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллаагүй албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

Мөн улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 2 ТАХ-ний гүйцэтгэгчид банкны баталгаагаар санхүүжилт олгохдоо 113.6 сая төгрөгийн техник хяналтын зардал, зохиогчийн хяналтын зардал, зураг төсвийн зардлыг суутгалгүй олгож, одоо болтол төсвийн дансанд төвлөрүүлээгүй тул төлбөрийн акт тогтоов.

Орхон аймагт 2020 оны шилжих болон 2021 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөгөөр 150 ортой хүүхдийн цэцэрлэг, 4 багийн төвийн цогцолбор барилга, ахмадын өргөө, хүүхэд хөгжил, хамгааллын төв, соёлын төв, өрхийн эрүүл мэндийн төв, 8 багт тоглоомын талбай, явган зам, гэрэлтүүлэг, үерийн суваг хийж, 2 УДДТ, 1,737 метр дулааны шугам, 7.8 км авто зам ашиглалтад орохоор байснаас дараах үр нөлөө гарсан байна. Үүнд:

- Баянцагаан болон Говил багийн цогцолбор байр, 150 ортой 1 цэцэрлэг, 1 өрхийн эрүүл мэндийн төв, сумын эрүүл мэндийн төвийн өргөтгөл ашиглалтад орсноор 156 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж, 36 хүн ажлын байраар хангагдсан байна.
- 5.7 км урттай хатуу хучилттай авто зам, Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн барилга ашиглалтад орсноор иргэд явган болон тээврийн хэрэгслээр зорчих тав тухтай нөхцөл сайжирсан байна.

Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтад шинээр эхлэх 7 ТАХ-ээс 1 ТАХ нь ажлын байр нэмэгдүүлэх “олон талт түншлэл” хөтөлбөр гэж тусгасан байх боловч тус ТАХ-ээр тоног төхөөрөмж нийлүүлж, ажлын байр нэмэгдээгүй, аймгийн 2 багт УДДТ, 1,737 метр дулааны шугам 2021 онд ашиглалтад орох байсан боловч тендер зураг төсөвгүй баталснаас шалтгаалан он дамжжээ.

Зарим хөрөнгө оруулалтын ТАХ-г нэгтгэж баталснаар үр нөлөөг тооцох боломжгүй болох, зураг төсөвгүй баталснаар хугацаа хойшилж он дамжих, улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад батлахгүй царцааснаар дуусаагүй барилга байгууламж нэмэгдэж хөрөнгө

оруулалтын үр нөлөөг бууруулж байна. Тухайлбал Орхон аймагт 250 хүүхдийн 2 сургууль, 928 хүүхдийн сургууль, Сургуулийн спорт зал, МСҮТ-ийн хичээлийн байр зэрэг ТАХ-ний төсвийг он дамжуулж баталснаар тухайн ТАХ-үүд 5-10 жил дамжин хэрэгжиж байна.

Иймд улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг тооцож, үр нөлөөгүй хөрөнгө оруулалтыг багасгахаар байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн тогтолцоо үр нөлөөгүйгээс төсөвлөлтийн шаардлага хангаагүй, орон нутгаас санал хүргүүлээгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсаар байна.
- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх тогтолцоо үр дүнтэй эсэхийг тодорхойлох боломжгүй байна.
- Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх бодлогын хэрэгжилт хангагдахгүй байна.
- Гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан хэдий ч төсөвлөлтөөс шалтгаалан ХАА хугацаа хоцорсоор байна.
- Захиалагчийн гэрээний хэрэгжилтийг хангуулах ажлын үр дүн өмнөх онтой харьцуулахад буурсан байна.
- Төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах хэрэгтэй байна.
- Засгийн газраас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг бодит гүйцэтгэлд олгож байгаа бөгөөд суутгах тооцоог үнэн зөв тооцоолж, хяналтыг сайжруулах шаардлагатай байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг тооцож, үр нөлөөгүй хөрөнгө оруулалтыг багасгахаар байна.

Аудитаар нийт 10,196.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 113.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 108.2 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, сахилгын хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, 9,974.4 сая төгрөгийн 4 зөвлөмж өгч, нэгтгэсэн тайланд тусгуулах 1 саналыг хүргүүллээ.

САНАЛ:

Үндэсний аудитын газарт:

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлэх талаар холбогдох газарт уламжлах.

Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын жагсаалтад үр нөлөөгүй ТАХ -г баталдаг байдлыг таслан зогсоох, эрх шилжүүлэхдээ төсвийн төсөвлөлтийн шаардлагыг хангуулах, холбогдох яамдаас ТЕЗ-д эрх шилжээгүй ТАХ-ний хяналтыг сайжруулах талаар тайланд тусгах.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараах албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга С.Батжаргал-д

- ТАХ-ний гүйцэтгэл, санхүүжилттэй холбоотой зөрчил арилахгүй, давтагдаж байгаад анхаарч, захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн, ашиглалтад хүлээн авсан байгууллага, комисс, төрийн албан хаагчдын ажлын хариуцлагыг сайжруулж, зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх;
- Эрх шилжээгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй ТАХ-д тавих захиалагчийн хяналтыг сайжруулах;

Аймгийн ГХБХБГ-т

- 2021 онд ашиглалтад орох ёстой эрх шилжээгүй 3,818.5 сая төгрөгийн 2 ТАХ-ний хэрэгжилтийг 2022 оны 09 дүгээр 01-ний дотор хангуулах;

ХББЗА ОНӨААТҮГ-т

- 2021 онд ашиглалтад орох ёстой эрх шилжсэн 6,155.9 сая төгрөгийн 4 ТАХ-ний хэрэгжилтийг 2022 оны 09 дүгээр 01-ний дотор хангуулах;

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

Холбогдох байгууллагын санал:



**МОНГОЛ УЛС
ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртбулаг баг,
Амарын талбай, Нутгийн удирдлагын ордон
Утас: 7035 5590, Факс: (976) 7035 2621
И-мэйл: info@erdenet.mn

2022. 05. 06. № 01/1094
танай _____-ны № _____-т

**ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

“Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”, “Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд өгөх санал байхгүй болно.

Аудитын дүн, дүгнэлтээр өгсөн зөвлөмж, албан шаардлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, цаашид анхаарч ажиллах болно.

ЗАСАГ ДАРГА

С.БАТЖАРГАЛ

Б.Навзмаа

Радлан хурцуйх.
М. 4/06
D:\My documents\A-5 doc
6122020665

Саналд өгсөн тайлбар: Аудитаар илэрсэн зөрчлүүдийг хүлээн зөвшөөрсөн тул тайланд засвар оруулах шаардлагагүй гэж үзлээ.